



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/399

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Нийтийн эзэмшлийн орон сууцны фасадны засвар (Булган сум)-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Гурван уулын хишиг" ХХК-тай 345 500 000 /Гурван зуун дөчин таван сая таван зуун мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Гурван уулын хишиг" ХХК-ийн захирал (Д.Мягмардорж)-д даалгасугай.

4. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010112

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 сарын  
23 өдрийн А/32 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	5,771,521	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	5,771,521	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	2,885,761	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	16,000,000	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	45 хоног	Ү.Бямбасүрэн
7	Гүйцэтгэлийн баталгааны дүн	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь.	Д.Батцогт
	Оро нутгаас авч ажиллах ажилчдын тоо	10 хүн	Н.Батжаргал